

**УВС АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ  
ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ**

2015 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 10

Улаангом.

Цагдаагийн байгууллагын 2015 оны эхний хагас жилийн ажлын  
тайлан сонсоод өгөх ЗӨВЛӨМЖ

Цагдаагийн байгууллагын 2015 оны төсвийн зарцуулалтын үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу хэвийн явагдаж ирсэн байна.

Цагдаагийн газрын вэб сайтанд “ Шилэн данс” цэс нээж санхүүгийн мэдээллүүдийг тогтмол байршуулан, байгууллагын санхүүгийн ил тод байдлыг хангах мэдээллийн самбар болон “ Нээлттэй хаалганы өдөр “ арга хэмжээ зохион байгуулж иргэд олон нийтэд санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийг хүргэж ажилласан байна.

Тус цагдаагийн газар нь 2015 оны эхний хагас жилд иргэд аж ахуйн нэгж байгууллагаас 1683 гомдол мэдээлэл хүлээн авч , гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 96,7 хувийг шийдвэрлэсэн байна.

Нийт шалгаж шийдвэрлэсэн гэмт хэрэг захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл бүрийг хуульд заасан хугацаанд 100 хувь барагдуулжээ.

Цагдаагийн газрын даргын 2015 оны А/14 дүгээр тушаалаар батлагдсан “ Сургалтын төлөвлөгөө”-ний хүрээнд албаны сургалтыг “ Танхим” “ Дадлага” “ Бие даах” гэсэн гурван хэлбэрээр долоо хоног бүрийн Лхагва, Баасан гаригт тогтмол явуулж хэвшсэн байна.

2015 оны эхний хагас жилийн байдлаар сургалтын төлөвлөгөөний дагуу 10 удаагийн 20 цагийн сургалтыг Алба хаагчийн сахилга ёс зүй, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам , Авлигын эсрэг хууль тогтоомж, Хүний эрх гэсэн сэдвүүдийн хүрээнд зохион байгуулан ажилласан байна.

Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны бодлогын хүрээнд цагдаагийн газраас цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг иргэд олон нийтэд түшиглэсэн ил тод шуурхай, чанартай хүргэх , иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зорилгоор “ Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг дөрвөн удаа зохион байгуулж хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлаа иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Цагдаагийн газрын 2015 оны эхний хагас жилийн ажлын тайлан сонсоод доорхи зөвлөмж өгч байна.

1. Сүүлийн үед гэмт хэргийн тоо хэмжээ буурахгүй байгаа шалтгаан, нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийж үүсээд байгаа нөхцөл байдлыг арилгахад бүх иргэд , байгууллагын анхаарлыг хандуулж ажиллах. Ялангуяа байгаль хамгаалах хууль, тогтоомжийн эсрэг гэмт хэрэг болон мал хулгайлах гэмт хэрэг нэмэгдэж байгаад анхаарч ажиллах.

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэчилсэн хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хатуу хучилттай зам дээр иргэдийн зам хөндлөн гарах гарцыг шаардлагын хэмжээнд хүргэж бий болгох. .

3. Аймгийн цагдаагийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник , технологи нэвтрүүлж ажиллахад анхаарах.

4. Цагдаагийн алба хаагчийг сахилга, ёс зүйн зөрчил гаргуулахгүй байх талаар анхаарч тэдний дунд явуулах ёс зүй , ёс суртхууны талын сургалтын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх.

ДАРГА



Н.ТЭЖЭЭ